

МОНГОЛЫН ЭХ БАРИГЧДЫН НИЙГЭМЛЭГИЙН
ТЭРГҮҮН



С.ДАВААСҮРЭН

ЭХ БАРИГЧ МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний хуралд 3 ба түүнээс дээш илтгэл, хэлэлцүүлж, хэвлүүлсэн байх /Бүтээлийн жагсаалт, илтгэлийн хураангуй, хөтөлбөрийг хавсаргана/.
2. Багц цагийн биелэлтийн шаардлагыг бүрэн хангаж, сүүлийн 3 жилд тус бүр 3 багц цагийн сургалтанд хамрагдсан байх ба үүний 1,5-аас доошгүй багц цагийг сургалт эрхлэх байгууллагаас /Мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан мэргэжлийн сургалтанд хамрагдаж албан ёсны гэрчилгээ авсан байх.
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хүн хүч, цаг хугацаа хэмнэсэн, ажил хөнгөвчилсөн эмчилгээ, үйлчилгээнд үр дүнтэй нь батлагдсан, байнга хэрэгжих боломжтой 3-аас доошгүй сайн туршлага нэвтрүүлсэн байх /Зургаар баримтжуулсан тайлан/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний хуралд 4 ба түүнээс дээш илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлсэн байх /Бүтээлийн жагсаалт, илтгэлийн хураангуй, хөтөлбөрийг хавсаргана/.
2. Багц цагийн биелэлтийн шаардлагыг бүрэн хангаж, сүүлийн 3 жилд тус бүр 3 багц цагийн сургалтанд хамрагдсан байх ба үүний 2-оос доошгүй багц цагийг сургалт эрхлэх байгууллагаас /Мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан мэргэжлийн сургалтанд хамрагдаж албан ёсны гэрчилгээ авсан байх.
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хүн хүч, цаг хугацаа хэмнэсэн, ажил хөнгөвчилсөн эмчилгээ, үйлчилгээнд үр дүнтэй нь батлагдсан, байнга хэрэгжих боломжтой 3-аас доошгүй сайн туршлага нэвтрүүлсэн байх /Зургаар баримтжуулсан тайлан/.
4. Шинээр төгсөж ирсэн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцаж буй 5-аас доошгүй эх баригчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх /Байгууллагын тодорхойлолтод дадлагажуулсан хүний нэр, дадлагажуулсан хугацааг тусгасан байна/.

5. Хэвлэлд мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй зөвлөмж, нийтлэл, бүтээл нийтлүүлсэн байна.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
2. Багц цагийн биелэлтийн шаардлагыг бүрэн хангаж, сүүлийн 3 жилд тус бүр 3 багц цагийн сургалтанд хамрагдсан байх ба үүний 2-оос доошгүй багц цагийг сургалт эрхлэх байгууллагаас /Мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан мэргэжлийн сургалтанд хамрагдаж албан ёсны гэрчилгээ авсан байх.
3. Эрдэм шинжилгээний хуралд 5 ба түүнээс дээш илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлсэн байх ба бүтээлийн жагсаалт, илтгэлийн хураангуй, хөтөлбөрийг хавсаргах. /үүнээс олон улсад 1-ээс доошгүй/
4. Эх барих, нярайн яаралтай тусламжийн чиглэлээр сургагч багшийн сургалтанд хамрагдсан, бие дааж дадлага сургалт зохион байгуулсан байх /Тайлан, баримтжуулалт, бодит үр дүн/
5. Мэргэжлийн чиглэлээр үндэсний хэмжээнд судалгааны ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн, тухайн багт үүрэгтэйгээр оролцсон байх
6. Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр олон нийтэд таниулах нөлөөллийн ажил /уулзалт, сургалт, хэлэлцүүлэг/ санаачлан зохион байгуулсан, эсвэл зохион байгуулах багт үүрэгтэйгээр оролцсон байх
7. Мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл бүхий ном, товхимол, зөвлөмж, гарын авлага, видео хийж олон нийтэд таниулсан байх
8. Мэргэжлээрээ олон улсын хурал, сургалтанд оролцсон байх /Гэрчилгээ/
9. Хувь хүний хөгжлийн сургалтаар ярих, илтгэх, зөвлөгөө өгөх, манлайлах ур чадварыг эзэмшсэн байх /Гэрчилгээ/
10. Сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан